

Дугаар:**ХУРЛЫН ТОВ**

Хурал болсон газар	Цахим хурал
Он сар өдөр	2021 оны 04 дугаар сарын 28-ны өдөр хуралдав.
Хурлын цаг	10:00-12:15 цагт боллоо.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга	ТУЗ-ийн дарга Д.Батжаргал
Хурлын ирц	71,8%
Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид	12 хувьцаа эзэмшигчид

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг батлах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

Тооллогын комиссын дарга Л.Хүрэлсүх:**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Компанийн тухай хуулийн 67.3.1, 69.1, 69.2, 69.8 болон “Женкотур бюро” ХК-ийн дүрмийн 3.15, “Женкотур бюро” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хуралд 57,437,916 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигч оролцож,

нийт саналын эрх бүхий 79,988,802 ширхэг энгийн хувьцааны 71,8% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дох заалт, компанийн дүрмийн 3.15 дахь заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 71,8%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Женкотур бюро ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнээр өнөөдөр хуралдах боломжтой болсон байна. Хурлын дэгийн та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх
- Компанийн танилцуулга
- 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан
- 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- 2021 оны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалыг хэлэлцэн батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ-с гаргасан ноогдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах
- Асуулт хариулт
- Саналын хуудас бөглөх заавар танилцуулах
- Санал хураалт
- Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- Хурлын дарга хурлыг хаах гэсэн дараалалтай явна.

Компанийн танилцуулгыг хурлын дарга Д.Батжаргал танилцуулна.

Батжаргал: Манай компанийн эрхэм зорилго нь Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох зорилготой. 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

2020 онд ТУЗ-ийн даргаар Д.Батжаргал, гүйцэтгэх захирлаар Б.Намуун ажиллаж байна.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдож бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 12 хурал биеэр болон эчнээ

саналын хуудсаар зохион байгуулж улирал бүрийн үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй танилцан холбогдох шийдвэр зөвлөмжийг өгч ажилласан.

Компани нь 2020 онд гадаад аялал хөл хорио тогтоохоос өмнө Хайнан, Тайланд, Дубай руу аялал гаргаж, дотоод аяллын идэвхитэй үйл ажиллагаа явуулсан 4 сарын хугацаанд ашиг орлолгоо нэмэгдүүлэх цогцолборуудад эвент арга хэмжээ зохион байгуулах, сувинер хийн борлуулалтаа нэмэгдүүлэх, Чингис хааны морьт хөшөөт цогцолборын тохижилтыг сайжруулж 2021 онд жуулчин хүлээн авахад бэлтгэх, 13-р зуун цогцолборт морин үзүүлбэрийн багтай хамтран ажиллаж жуулчдад үзүүлэх үйлчилгээгээ өргөжүүлэх ажлуудыг гүйцэтгэх удирдлагын баг өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашигласан гэж төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж болно.

ҮЗҮҮЛЭЛТ	2019 гүйцэтгэл /мян.төг/	2020 төсөвлөсөн /мян.төг/	2020 гүйцэтгэл /мян.төг/
Борлуулалтын орлого	4,702,205	1,181,685	566,869
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,864,800	719,507	1,151,099
Нийт ашиг	1,837,405	462,178	(584,230)
Санхүү ба бусад орлого	2,813		38,745
Үйл ажиллагааны зардал	400,974	163,473	363,120
Бусад зардал	41,625	-	52,886
Төлөвлөгөөт зардал	-	181,696	
Бусад олз, гарз	247	-	10,323
Татварын өмнөх ашиг	1,397,866	117,009	(951,168)
Орлогын татварын зардал	144,088	-	1,068
Тайлант жилийн цэвэр ашиг	1,253,778	117,009	(952,236)



Тайлбар:

2020/2019 оны гүйцэтгэлтэй харьцуулвал:

- 2020 оны нийт орлогын гүйцэтгэлийг 2019 оны нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад - 88% бууралттай,
- 2020 оны нийт зардлын гүйцэтгэлийг 2019 оны нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад - 53% бууралж танасан,
- 2020 оны нийт цэвэр ашгийн гүйцэтгэлийг 2019 оны нийт ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад -176% бууралтай гарсан.

2020 оны төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулвал:

- 2020 оны нийт орлогын төлөвлөгөөг - нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 48% биелсэн,
- 2020 оны нийт зардлын төлөвлөгөөг - нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 77% хэтэрсэн,
- 2020 оны нийт цэвэр ашгийн төлөвлөгөөг - нийт цэвэр ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 8,1 дахин бага биелсэн

2020 онд ЭС ЖИ ЭМ ДИ аудит ХХК хараат бус аудитын ажлыг хийсэн.

“Женкотур бюро” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна. “ гэж дүгнэсэн.

2020 оны төлөвлөгөө нь дэлхий нийтээр тархаад байгаа COVID-19 цар тахлын нөлөөгөөр өмнө нь төлөвлөж байсан борлуулалтын орлого 1,18 тэрбум хараахан биелэгдэх боломжгүй болсон.

Хөл хорионы үеэс бусад үеүүдэд Чингис хааны морьт хөшөөт цогцолбор, 13-р зуун цогцолбор болон гадаад, дотоод аяллын бүтээгдэхүүнүүдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор бүтээгдэхүүнээ хөгжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх тогтмолжуулах, ашиг орлогоо өсгөхийг зорилго болгон ажиллаа. Дээрхи ажлын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдээс:

- Солирын бороо
- Монгол бичгийн өдөрлөг
- Галын тахилга
- Нууц нүүдэлчин
- Морин циркийн үзүүлбэр гэх мэт эвент ажлуудыг зохион байгуулсан.

2020 оны төлөвлөгөө зорилтын хүрээнд өөрсдийн нөөц бололцоонд тусгуурлан дараах тохижилт техник угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанар, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор тодорхой бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Чингис хааны морьт хөшөөт цогцолбор

- Музейн шинэчлэл
- Ресторан
- Зүлэгжүүлэлт

- Кофе шопын тохижилт шинээр хийсэн
- Дотор дулаалга дээвэр
- Шат

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл болон гадаад, дотоод орчин нэн ялангуяа ковид-19 вирус аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөөллүүдийг үндэслэн орлогоо тогтворжуулж зардлаа хэмнэх үндсэн зорилотойгоор бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ажилтнуудын ур чадварыг сайжруулах, маркетингийн оновчтой бодлогуудыг хэрэгжүүлэх дээр анхаарч 52 бүлэг 161 ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Голлор үйл ажиллагаанууд:

- Үндсэн болон туслах бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтрүүлэх
- Нийгмийн хариуцлагын хүрээнд ахмадуудад чиглэсэн Гэрэлт түүх хүүхдүүдэд чиглэсэн Гэрэлт ирээдүй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- Одоогийн вэбсайт орчин үеийн чиг хандлагын дагуу хөгжүүлж шууд борлуулалт хийх боломжтой болгох, бусад төхөөрөмжүүдэд ашиглах боломжтой болгож аппликешн нэвтрүүлэх
- Олон улсын зах зээл дээрхи харилцагчдын тоо, борлуулалтын сувгуудыг нэмэгдүүлэх
- Цогцолборуудыг бүтээн байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх үндсэн зорилго бүхий анхны төслүүдийг шинэчлэн сайжруулж хэрэгжүүлэх.
- Дотоод гадаад аяллууд зохион байгуулах
- Ажилтнуудын ур чадварыг сайжруулах сургалт хөгжлийн ажлууд хэрэгжүүлэх
- Ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлэх
- Үр дүнд суурилсан цалингийн бодлогыг сайжруулж хэрэгжүүлэх
- ХАБЭХ-н үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулж сайжруулах
- Чингис хааны морьт хөшөөний сувинерийн шинэ бүтээгдэхүүн гаргах

№	Зардлын нэр	Тоо	Сарын	Жилийн	Нийт
			зардал	зардал	(төгрөг)
1	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин	3	250,000	3,000,000	9,000,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн цалин	1	350,000	4,200,000	4,200,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	4	150,000	600,000	600,000
	Нийт		850,000	7,800,000	13,800,000

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн танцуулга.

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах нэр дэвшигч нар дэвшиж байгаа.

Э.Билгүүн, Б.Намуун, Б.Октябрь, Т.Сайнбаяр, Х.Цэндбаяр, Д.Цэрэнчимэг, О.Энэрэл

Хараат бус ТУЗ-ийн гишүүдэд

Д.Батжаргал, Г.Өсөхбаяр, Ц.Түмэнхишиг, Ү.Тэмүүжин

Хурлын дарга: ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах.

НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ТОГТООЛ



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь нэгдэл, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн өнгө санал хураалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Женко тур бюро” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг үндэслэн 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлангахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэн Д.Батжаргал-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ГҮР ОРЛОН ГҮЙЦЭГНЭГЧ

Д.БАТЖАРГАЛ

Тооллогын комисс:

**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2021 оны 04 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

“Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Женко тур бюро” ХК-ийн саналын эрхтэй нийт 79,988,802 ширхэг хувьцаанаас 71,8 % буюу 57,437,916 ширхэг хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % буюу 57,437,916 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
57,437,916	100%	0	0%	0	0%

2. Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 57,437,916 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
57,437,916	100%	0	0	0	0

3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 57,437,916 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
57,437,916	100%	0	0	0	0

4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % буюу 57,437,916 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
------------	------------	------------

Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
57,437,916	100	0	0	0	0

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % буюу 57,437,941 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал:

Ердийн гишүүдэд:

	ТУЗ-ийн ердийн гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	ЭНХБАТ БИЛГҮҮН	16,656%	57,044,963
2	БАТТУЛГА НАМУУН	16,719%	57,260,299
3	БАЯР ОКТЯБРЬ	16,656%	57,044,963
4	ТҮМЭНБАЯР САЙНБАЯР	0.00006	219
5	ХАДТМАА ЦЭНДБАЯР	16,656%	57,044,963
6	ЗУНДУЙДАВАА ЦЭРЭНЧИМЭГ	16,656%	57,044,963
7	ОТГОНБАЯР ЭНЭРЭЛ	16,656%	57,044,963

Хараат бус гишүүдэд:

	ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр	Саналын Хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
8	ДОРЛИГЖАВ БАТЖАРГАЛ	0.6	1.175.529
9	ГАНБОЛД ӨСӨХБАЯР	32,4%	55,869,653
10	ЦЭРЭНДАВАА ТҮМЭНХИШИГ	33,333%	57,044,744
11	ҮҮРЦАЙХ ТЭМҮҮЖИН	33,333%	57.044.963

тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Ердийн гишүүнд:

1. ЭНХБАТ БИЛГҮҮН
2. БАТТУЛГА НАМУУН
3. БАЯР ОКТЯБРЬ
4. ХАЛМТАА ЦЭНДБАЯР
5. ЗУНДУЙДАВАА ЦЭРЭНЧИМЭГ
6. ОТГОНБАЯР ЭНЭРЭЛ

Хараат бус гишүүнд:

7. ГАНБОЛДЫН ӨСӨХБАЯР
8. ЦЭРЭНДАВАА ТҮМЭНХИШИГ
9. ҮҮРЦАЙХ ТЭМҮҮЖИН

Тооллогын комиссын дарга:

/Л.Хүрэлсүх /

Тооллогын комиссын гишүүд:

/Б.Мөнхтулга/

/Б.Энхжаргал/

хурлын дарга: ХЭ-ийн хурлаар санал хураалт амжилттай явагдаж дууслаа. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүддээ ажлын амжилт хүсч, компанийг үр ашигтай хамтран ажиллах болсонтой талархаж байна. Бүгдэнд амжилт хүсье. За тогтоол уншиж танилцуулья.

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, “Женко тур бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

“Женко тур бюро” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Женко тур бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт 1-р баталсугай.

“Женко тур бюро” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөв батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2021 оны төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хавсралт №1-ээр баталсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 7 дэх заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Женко тур бюро” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

1. Э.БИЛГҮҮН
2. Б.НАМУУН
3. Б.ОКТЯБРЬ
4. Х.ЦЭНДБАЯР
5. Д.ЦЭРЭНЧИМЭГ
6. О.ЭНЭРЭЛ

Хараат бус гишүүнээр

7. Ц.ТҮМЭНХИШИГ
8. Ү.ТЭМҮҮЖИН


9. Г.ӨСӨХБАЯР нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

/Д.БАТЖАРГАЛ/

Хурлын дарга: ХЭ-ийн хуралд онлайн горимоор оролцсон, санал, зөвлөмжөө өгсөн, саналын хуудсаар оролцсон та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Шинээр ТУЗ-д сонгогдсон гишүүд, ажлын хамт олон амжилт хүсч, COVID-19 даван туулж, компани ашигтай ажиллах болтугай гэж хүсэн ерөөе. Өнөөдрийн ХЭХурал хаасныг мэдэгдье.

Хурлын дарга:...../Д.Батжаргал/

Тэмдэглэл хөтөлсөн:........../О.Баярצעэг/